

Орлуулах үйлдэл

Шинээр гарсан монгол оффисын програмд ганц үйлдэл дутуу хийгджээ. Энэ нь үгийг хайж олоод өөр үгээр орлуулах үйлдэл юм. Иймд энэ алдааг засах програмыг бичнэ үү.

Input

Оролтын эхний мөрөнд 100-аас илүүгүй урттай, латин цагаан толгойн жижиг үсгүүд болон хоосон зайнаас бүтсэн текст өгөгдөнө. Дараагийн мөр бүрт мөн л латин цагаан толгойн жижиг үсгүүдээс тогтох хос үг зайгаар тусгаарлагдан өгөгдөнө. Эхний үгийг текстээс олж устгаад оронд нь хоёр дахь үгийг бичих хэрэгтэй. Орлуулгуудыг өгөгдсөн дарааллаар хийнэ. Анхны текстэд үгүүдийг ганц хоосон зайгаар тусгаарласан байна.

Output

Гаралт дээр хувиргагдсан текстийг гаргана. Үгүүд хоорондоо ганц хоосон зайгаар тусгаарлагдсан байх ёстой.

Example

Input:

the quick brown fox jumps over the lazy dog
brown red
lazy black
the a

Output:

a quick red fox jumps over a black dog

Input:

adam is a man eva is a woman
man woman
woman man

Output:

adam is a man eva is a man